



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Биеийн тамир спорт, урлагийн хамтлагийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, нэгж түүний удирдалагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2006 оны А/165 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын албан хаагчдын дунд, биеийн тамир, спорт, урлагийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах, идэвхжүүлэх Биеийн тамир спорт, урлагийн хамтлагийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсугай.

Хамтлагийн ахлагч: Мэдээллийн технологи, цахим хөгжил хариуцсан ажилтан

Гишүүд: Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн

Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд хариуцсан менежер

Нарийн бичгийн дарга: Архив бичиг хэргийн эрхлэгч

2.Албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, спорт, урлагийн олон талт арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг Биеийн тамир спорт, урлагийн хамтлагийн ахлагчид үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллахыг Захиргаа санхүүгийн хэлтэс (Х.Содномдэмбэрэл)-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



115 :500165